



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/68

Хужирт сум

Гамшгаас хамгаалах бүх нийтийн  
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн  
хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 104 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн итгээдийг Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2021 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 06<sup>00</sup> цаг хүртэл сунгасугай.

2. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан дараах хязгаарлалтуудыг тогтоосугай.

а. Эм, эмийн хэрэгсэл, хүнс, түлш, шатахуун, малын өвс тэжээлийн тээврээс бусад сумын нутаг дэвсгэрээс гарах болон орох тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг дээрх хугацаанд зогсоох;

б. Эрүүл мэндийн тусламж авах болон буяны ажилтай иргэд сумын Шуурхай штабаас зөвшөөрөл авч зорчих, буяны ажлаар хот, аймаг, сумаас ирэх болон буцах иргэдийг түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авах;

с. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын 5-10 хувийг ажлын байран дээр ажиллуулах арга хэмжээ авах;

д. Эрүүл мэндийн төв, эмийн сан, шатахуун түгээх станц, уст цэгээс бусад төрийн болон аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр хориглох;

е. Архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхийг 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 06.00 цагаас 2021 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн 06.00 цаг хүртэл хориглох;

е. Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх зорилгоор цахимаар хичээллүүлэх;

3. Коронавируст халдварын цар тахлын цаг үеийн нөхцөл байдлын талаар иргэдэд үнэн зөв мэдээлэл өгч, зөвлөмж хүргүүлж, хүнсний бүтээгдэхүүн, эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн зохиомол хөөрөгдөлд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулж ажиллахыг Цагдаагийн тасгийн дарга, дэд хурандаа Х.Түмэнбаяр, Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Доржсэмбэ) нарт даалгасугай.

4. Бүх төрлийн хүнсний болон бараа бүтээгдэхүүнд зохиомол үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байхыг худалдаа, бизнес эрхлэгчдэд үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, газруудад (Эрүүл мэндийн төв, шатахуун түгээх станц, эмийн сан, уст цэг, хүнсний түгээлт) хяналтын системийг тогтмол хөтлүүлж, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэм, ариутгал халдваргүйжүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга З.Цэцэгмаа, Мал эмнэлийгийн тасгийн Улсын байцаагч Б.Ичинхоролцэвэлмаа нарт даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Б.Дэмбэрэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ